



ДОРНОГОВЬ АЙМАГ
ДЭЛГЭРЭХ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 03 сарын 17 өдөр

Дугаар А/25

Хонгор

Газар эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага
худалдаа зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59.1.23, 66 дугаар зүйлийн 66.1, 66.3 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журам", Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын "Сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулах тухай" 2026 оны 9/01 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын "Газар зохион байгуулалтын төлөвлөгөө"-д тусгагдсан газар эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдааг зохион байгуулсугай.

2.Дуудлага худалдаагаар эзэмшүүлэх, ашиглуулах газрын байршил, хэмжээ, зориулалт, хугацаа, дуудлага худалдааны анхны үнэ, дэнчингийн хэмжээг хавсралтаар баталсугай.

3.Газар эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдааг 2026 оны 04 дүгээр сарын 24-ний өдөр зохих журмын дагуу цахим хэлбэрээр зохион байгуулахыг Газрын даамал (И.Болортуяа)-д үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын орлогч (М.Ганбаатар)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТХҮҮ

4426010053

Сумын Засаг даргын 2026 оны 02 дугаар
сарын 17-ны өдрийн 142 дугаар
захирамжийн хавсралт

ГАЗАР ЭЗЭМШҮҮЛЭХ, АШИГЛУУЛАХ ГАЗРЫН БАЙРШИЛ, ХЭМЖЭЭ,
ЗОРИУЛАЛТ ДУУДЛАГА ХУДАЛДААНЫ АНХНЫ ҮНЭ,
ДЭНЧИНГИЙН ХЭМЖЭЭ

1. Дэлгэрэх сумын Цагаанхад багийн нутаг дэвсгэр Чандмань уул хаягт шатахуун түгээх газар, агуулахын зориулалтаар 3889 м² газрыг газар эзэмшүүлэх, ашиглуулах хугацаа 40 жил, нэгж талбарын төлөвлөлтийн дугаар 5099722, дуудлага худалдааны анхны үнэ 2333400 төгрөг, дэнчингийн 233340 төгрөг.

2. Дэлгэрэх сумын Цагаанхад багийн нутаг дэвсгэр Чандмань уул хаягт уул уурхайн үйлдвэрлэлийн барилга, байгууламжийн зориулалтаар 76371 м² газрыг газар эзэмшүүлэх, ашиглуулах хугацаа 40 жил, нэгж талбарын төлөвлөлтийн дугаар 5099723, дуудлага худалдааны анхны үнэ 24438720 төгрөг, дэнчингийн 2443872 төгрөг.